



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/357

Есонбулаг

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 15 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Оросын Холбооны Улсын Онцгой байдлын яамнаас ирүүлсэн урилгын дагуу Онцгой байдлын ерөнхий газраас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Оросын Холбооны Улсын Москва хотод зохион байгуулагдах "Иж бүрэн аюулгүй байдал-2024" тоног төхөөрөмжийн олон улсын үзэсгэлэнд оролцоход Онцгой байдлын газрын дарга Ц.Лувсанжамцад зардлын дэмжлэг олгосугай.

2. Шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг ханган, хөрөнгийн зарцуулалт, арга хэмжээний үр дүнг тайлагнан ажиллахыг Онцгой байдлын газрын дарга (Ц.Лувсанжамц)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

